



ДУНГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН  
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 94

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж худалдах,  
данснаас хасах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Хүн эмнэлэгийн барилгын дуудлага худалдаагаар худалдах доод үнийг 50 хувиар буулган 17,500,000 /арван долоон сая таван зуун мянга/ төгрөгөөр худалдах, Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 808,500 /найман зуун найман мянга таван зуу/ төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ анхны үнээ нөхсөн зуслангийн байшинг акталж устган, ашиглагдаж болох эд зүйлсийг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 сарын 06—ны өдрийн “Хөрөнгө худалдах тухай” 243 дугаар тогтоол, 2013 оны 11 сарын 20-ны өдрийн “Хөрөнгө худалдах тухай” 203 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

3. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ

1160208